



БАТЛАВ:
ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД САЙД БӨГӨӨД
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН ДАРГА
М.БАЯРМАГНАЙ

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН "БҮТЭЭЛЧ АЯН" УРАЛДААНЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Монгол Улсад Эрчим хүчний салбар үүсч хөгжсөний **100** жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд тус салбарын үйлдвэр компаниудын дунд үр ашгийг дээшлүүлэх, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, салбарын норм стандартыг боловсронгуй болгох, зардал бууруулах чиглэлээр хийгдсэн ажлыг сурталчилан таниулахад энэхүү ажлын зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ, хугацаа

Уралдаанд эрчим хүчний салбарын үйлдвэр компани /тусгай зөвшөөрөл эзэмшигч/-уудын инжөнөр төхникийн ажилтан, ажиллагсадыг омчийн хэлбэрээс үл хамааран оролцуулна.

Эрчим хүчний салбарт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хүрээнд хийгдсэн ажлуудыг тооцохгүй.

"Бүтээлч аян"-ыг **2018 оны 01 дүгээр сарын 01-нээс 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн** хооронд санаачилсан бүтээлүүдийг хамруулна.

Гурав. Үнэлэх шалгуур үзүүлэлт

Биет болон биет бус бүтээл байж болно. Ирүүлсэн бүтээлийг дараах үндсэн шалгуураар үнэлнэ. Үүнд:

- | | |
|--|---------|
| ✓ Дэвшилтэт шинэ техник технологи нэвтрүүлсэн байдал | 20 оноо |
| ✓ Байгаль орчинд ээлтэй технологи | 15 оноо |
| ✓ Хэмнэлт гаргаж, зардлыг бууруулах | 20 оноо |
| ✓ Үр дүнг харьцуулалтаар харуулсан байдал | 15 оноо |
| ✓ Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал | 15 оноо |
| ✓ Шинэ бүтээл, ашигтай загварын гэрчилгээ | 15 оноо |

Дөрөв. Хүлээн авах хугацаа, хаяг

Бүтээлийн материалыг **2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 17:00 цагаас** өмнө Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон ehbhzg@gmail.com цахим хаягаар ирүүлнэ.

Бүтээлийг гэрэл зураг, бичлэг, гарсан үр дүнг тайлбарын хамт дэлгэрэнгүй ирүүлэх.

Холбоо барих хаяг, утас: Эрчим хүчний яам, Улаанбаатар-17060, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Засгийн газрын 14-р байр, 303 тоот

Б.Баясгаланбаатар /99074766/, У.Нямгэрэл /88091291/

Утас: 51-267064, E-mail: ehbhzg@gmail.com

Тав. Шалгаруулалт

“Бүтээлч аян”-ыг Эрчим хүчний яамнаас томилсон дэд ажлын хэсэг шалгаруулна. Дэд ажлын хэсгийн гишүүд тус бүр оноо өгөх ба гишүүдийн нийлбэр оноог нэгтгэж хамгийн өндөр оноо авсан бүтээлийг шалгаруулна. Ажлын хэсгийн гишүүд нэг бүтээлийн ижил шалгуур үзүүлэлтэд өгсөн онооны зөрүү 3 онооноос хэтрэхгүй байна.

Зургаа. Шагнал урамшуулалт

“Бүтээлч аян”-д түрүүлсэн бүтээлийг өргөмжлөл, 7,000,000 /долоон сая/ төгрөгөөр, хоёрдугаар байр эзэлсэн бүтээлийг өргөмжлөл, 5,000,000 /таван сая/ төгрөгөөр, гуравдугаар байр эзэлсэн бүтээлийг өргөмжлөл, 3,000,000 /гурван сая/, тусгай байр хоёр буюу тус бүр 1,500,000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгөөр тус тус шагнана. Шалгарсан шилдэг бүтээлүүдийг олон нийтэд сурталчлан таниулна.

ТАНИЛЦСАН:

Төрийн нарийн бичгийн дарга

Б.Насантогтох

ХЯНАСАН:

Дэд ажлын хэсгийн дарга,

Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга

Д.Батзориг

БОЛОВСРУУЛСАН:

Дэд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,
ЭХБХЗГ-ын Цахилгааны хэлтсийн
ширинооч

Б.Баясгаланбаатар

ЭХБХЗГ-ын Цахилгааны хэлтсийн
ахлах мэргэжилтэн

У.Нямгэрэл